



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 65 дугаар зүйлийн 65.6 дах хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02, 03 дугаар тогтоолуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын албан хаагчдын “Албан тушаалын тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг журмын дагуу байгууллагын чиг үүрэг, стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны шинжилгээг үндэслэн албан тушаал бүрээр боловсруулахыг ажлын хэсэг /Х.Жаргалсайхан/-т даалгасугай.

3. Албан тушаалын тодорхойлолтын төслийг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Х.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.


ДАРГА  Ч О Д Н А С А Н



Тушаал-2019

115050000087

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2011 оны 02 дүгээр сарын 12-ны
өдрийн 4/25 тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Жаргалсайхан

Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд:

М.Энхболд

Өмчийн төлөөлөл, менежмент, хувьчлалын
хэлтсийн дарга

Ч.Ням-Оюун

Өмчийн хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн
дарга

А.Нарантуяа

Хуулийн зөвлөх

Я.Одгэрэл

Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн

Ж.Сувданзаяа

Өмчийн хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн
мэргэжилтэн

Ажлын хэсгийн нарийн
бичиг:

Н.Золжаргал

Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах, хүний
нөөцийн мэргэжилтэн